



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 5/23

Ховд

Э.Уртнасанд сахилгын шийтгэл ногдуулах тухай


Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалт, Монгол Улсын Сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ын 1.3.1, Ховд аймгийн Онцгой комиссын 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 44 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн “Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх вакцины хамралтыг эрчимжүүлэх тухай” 02 дугаар албан даалгаврын дагуу вакцинжуулалтыг хангалтгүй буюу 44.31 хувьтай хамрагдуулж албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй Үенч сумын Засаг дарга Э.Уртнасанд сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж дахин зөрчил гаргахгүй ажиллахыг Э.Уртнасанд даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Дэлгэрсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ